



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/24

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны Аймгийн төсөв батлах тухай 12/09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "2020 онд аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, жагсаалтын 2 дахь заалтын дагуу Төрийн албанд автомашин худалдан авах, аймаг, сумдын төрийн байгууллагын автомашины засварын зардлаас Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын автомашин худалдан авах зардалд 40.000.000 (дөчин сая), Баруунбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газрын автомашин худалдан авах зардалд 40.000.000 (дөчин сая), аймгийн Улсын бүртгэлийн хэлтэсд автомашин худалдан авах зардалд 30.000.000 (гучин сая), автомашин худалдан авахад зарцуулах 110.000.000 (нэг зуун арван сая) төгрөгийн үлдэгдэл 55.000.000 (тавин таван сая) төгрөгийг сумдын Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын автомашины засвар шинэчлэлд зарцуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Бүрд сумын Засаг дарга (Г.Баярмөнх), Баруунбаян-Улаан сумын Засаг дарга (Д.Баатарчулуун), Улсын бүртгэлийн хэлтэс (А.Мөнхтөр)-т тус тус шилжүүлсүгэй.

2. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100049